

**МАНЖ ЧИН УЛСЫН ЭХЭН ҮЕД ТӨРӨӨС ОРОН НУТАГТ
ХЭРЭГЖҮҮЛСЭН ДАВСНЫ БОДЛОГО**
(Алишаагийн хошууд хошууны жишээн дээр)

Р. ХАС-ОЧИР

Агуулгын товч: Алишаагийн Хошууд хошуунд хэрэгжүүлсэн Чингийн төрийн давсны бодлогын мөн чанар нь төрийн эрх ашигийг ямагт эн тэргүүнд тавих явдал байсан нь тодорхой харагдаж байна. Тэд төрийн эрх ашигт ноцтой сөрөг нөлөө үзүүлээгүй тохиолдолд тодорхой хэмжээгээр дэмжсэн бодлого хэрэгжүүлж, харин сөргөөр нөлөөлөх үед хяналт, хязгаарлалтын хатуу бодлогыг явуулж байсан онцлогтой. Тэнгэр тэтгэгч хааны үед Алишаагийн Хошууд хошууны давсны үйл хэрэгт харьцангуй зөөлөн бодлого баримталж, хошууны хүсэлт гуйлтыг зөвшөөрч, нааштайгаар хүлээн авч байжээ. Давсны үйл хэрэг нь Хятад газрын зах зээл хийгээд Алишаагийн Хошууд хошууны хоёр талын эрх ашигт харилцан ашигтай байсан тул Чингийн төр дэмжих бодлого баримталж байв. Сайшаалт ерөөлт хааны эхэн үед Алишаагийн Хошууд хошуунд хэрэгжүүлсэн давсны бодлогын гол онцлог нь амуу будаа болон онгоц хийх модны тоог багасгаж, улмаар хязгаарлах зарчмаар үргэлжилсэн юм. Өмнөх үетэй харьцуулбал харьцангуй хатуу чанга бодлого хэрэгжүүлж, давс тээвэрлэх онгоцны тоог багасгах, усан замыг хаах, хориглох зэргээр үргэлжилж, Алишаа хошууны давсны үйлдвэрлэлийн эрх ашигийг бус төрийн эрх ашиг, Хятад газрын зах зээл, албан давсны эрх ашигийг хамгийн эхэнд тавих болсон онцлогтой байна. Дээрх хоёр хаадын үеийн давсны бодлого нь: нэгдүгээрт, Чингийн төр өөрсдийн дотоодын зах зээл, албан давсны үйлдвэрлэлийг хамгаалах явдалтай холбоотойгоор хэрэгжиж байжээ. Хоёрдугаарт, Алишаагийн засаг ноёд болон Чин улсын хаадын хоорондын харилцаа, засаг ноёдын төрд байгуулсан цэргийн гавьяа, худ ургийн холбоо буюу төрийн эфү болсон явдалтай холбоотойгоор хэрэгжиж байв. Лувсандорж, Ванчинбамбар зэрэг засаг ноёдын үед Чингийн төрийн давсны бодлого харьцангуй зөөлөн, дэмжсэн шинжтэй байсан бол Махбалын үед харьцангуй хатуу чанга, хязгаарлалтын бодлогыг хэрэгжүүлэх болсон байна. Чингийн төрөөс Алишаагийн Хошууд хошуунд хэрэгжүүлсэн давсны бодлогын судалгаа нь Манж Чин улсын зүгээс Монгол нутагт баримтлан явуулж, хэрэгжүүлж байсан бодлого, түүний мөн чанар, онцлогийг таньж мэдэх, тодруулахад зохих хувь нэмэр болох ач холбогдолтой болно.

Түлхүүр үг: Манж Чин улс, Алишаагийн хошууд хошуу, давс, төрийн давсны бодлого, давсны орд, давсны олборлолт, давсны худалдаа, давсны татвар, давсны худалдаачин

Удиртгал

Одоогийн БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны томоохон аймгийн нэг нь Алшаа аймаг билээ. Түүний засаг захиргааны төв нь Баян хот юм. Алшаа аймаг нь “Алшаа зүүн хошуу”, “Алшаа баруун хошуу”, “Эзнээ хошуу” гэсэн гурван хошуунаас бүрддэг. Алшаагийн хошуудууд бол Ойрад Монголын баруун гарын үр хойчис билээ. Чин улсын үеийн Алшаа хошууны нутаг нь зүүн зүгт Алаг уулаар Нинься мужтай зах нийлж, баруун зүгт Горной хүрч, Эзнээ голын Торгууд хошуутай залган, өмнө зүгт Ланьжоу, Ганжоу хотод тулан, умард зүгт элсэн говиор Халхын Засагт хан аймагтай хиллэж байв. Энэ нь Алшаагийн газар нутаг бол байгалийн баялгийн арвин их нөөц, давсны олон орд газартай нутаг юм. Энэ өгүүлэлдээ Манж Чин улсын төрөөс Ашаагийн хошууд хошуунд хэрэгжүүлсэн давсны бодлогыг тодруулан судалж, өөрийн санал дүгнэлтийг дэвшүүлэхийг зорьсон болно.

Энэхүү судалгаанд ӨМӨЗО-ны Алшаа аймгийн Алшаа Зүүн хошууны архивын сангийн 101-108-р хөмрөгт хадгалагдаж буй архивын баримтуудыг үндсэн эх хэрэглэгдэхүүн болгон ашиглав. Мөн Алшаа зүүн хошууны архивын зүгээс Өвөр Монголын эртний судар бичгийг эмхэтгэх газартай хамтран эмхэтгэн найруулсан “Алшаа Хошууд хошууны монгол түүхэн данс” (бүгд 70 дэвтэр)¹, “Алшаа Хошууд хошууны манж түүхэн дансны сонгомол” (бүгд 10 дэвтэр)²-ыг судалгааны үндсэн хэрэглэгдэхүүн болгон ашигласан болно.

Өвөр Монголын эрдэмтэд Чин улсын үеийн төрийн давсны бодлого, давсны худалдааны түүхийг анхааран судалжээ. Судлаач Мөрөн “Өвөр Монголын давсны үйлдвэрлэлийн түүх”³ бүтээлдээ Өвөр Монголын давсны үйлдвэрлэлийн ерөнхий хөгжлийг нарийвчлан авч үзжээ. Мөн “Алшаа аймгийн давсны хэрэг явдлын хөгжлийн түүх”⁴ бүтээлдээ Чин улсын үеэс 1985 он хүртэлх Алшаагийн давсны үйлдвэрлэлийн түүх, давсны үйлдвэрлэлийн зохион байгуулалт, удирдлага, зохицуулалт, тээвэр, борлуулалт зэрэг асуудлыг судалсан байна. Тэрчлэн түүний “Өвөр Монголын давст нуурын эх баялаг”⁵, “Шилийн гол аймгийн давсны хэргийн түүх”⁶, “Ордос давсны үйлсийн түүх”⁷ зэрэг судалгааны бүтээлүүдийг энд дурдаж болно.

Өргэдэй Тайван “Давсан нуурын давсны тээврийн зам чиглэл ба түүний түүхэн улбаа”⁸ өгүүлэлдээ Өвөр Монголд япончуудын хийсэн судалгааны материалыг ашиглан, Чин улсын сүүл үеэс Дэлхийн хоёрдугаар дайны өмнөх үе хүртэлх хугацаанд Ээж нуураас дөрвөн зүг найман зовхист нэвтэрч байсан давсны 10 гол зам байсныг нягтлан тогтоожээ.

¹ 苏雅拉图, 布仁巴依尔; (2018) 《清代阿拉善和硕特旗蒙文档案》70卷, 呼和浩特: 远方出版社。

² 内蒙古自治区阿拉善左旗档案史志局; (2016), 清代阿拉善和硕特旗满文档案选编. 10卷, 北京: 国家图书馆出版社。

³ 牧寒; (1987), 《内蒙古盐业史》, 呼和浩特: 内蒙古人民出版社。

⁴ 牧人; (2007), 《阿拉善盟盐业志》, 呼和浩特: 内蒙古人民出版社。

⁵ Мөрөн. (2006). *Өвөр Монголын давсан нуурын эх баялаг*. Хөх хот: ӨМАХХ.

⁶ Мөрөн. (2006). *Шилийн гол аймгийн давсны хэргийн түүх*. Хөх хот: ӨМАХХ.

⁷ 牧人, 袁宪金; (2003), 《鄂尔多斯盐业史》, 呼和浩特: 内蒙古人民出版社。

⁸ 周太平; (2008) 《达布苏淖尔盐路及其历史轨迹》, 首届全国乌珠穆沁历史文化学术研讨会文集)

Хятадын эрдэмтэд Чин улсын үеийн төрийн давсны бодлого, түүний хэрэгжилтийг судалсан бүтээлүүдийг бичиж хэвлүүлсэн байна. Лян Лишягийн “Алшаа монголчуудын судалгаа”⁹ бүтээлдээ Алшаа Зүүн хошууны түүх, соёл архивын газрын хятад хөмрөгийг ашиглан Чин улсын эхэн үеийн Алшаа Монголын давсны үйлдвэрийн түүхэн хөгжлийн улбаа мөрийг нарийвчлан судалжээ. Мөн Чин улсын эхэн үеийн Алшаа Монголын давсны үйлдвэрлэлийн хөгжилд дүн шинжилгээ хийж, өөр өөр цаг үеийн бодлогын өөрчлөлтүүд, тэдгээрийн дотоод бүсийн давсны зах зээлд үзүүлэх нөлөөллийг судлан үзсэн байдаг.

Ван Зэминь “Шөргийн боомт хийгээд Хятадын умард хил хязгаар”¹⁰ хэмээх бүтээлдээ давсны үнэ, татвар, тээвэрлэлтийн бодлого зэрэг Алшаагийн давсны асуудалд ямар нэгэн байдлаар холбогдох асуудлуудыг тодорхой хэмжээнд дурдахын хамт давсны үйлдвэрлэлийн судалгаанд хамаарах зарим үнэ цэнтэй мэдээлэл оруулжээ.

Тань Рэньюэ-гийн “Дундад улсын давсны үйлс: түүх, орон нутгийн боть”¹¹ бүтээлд бүх улсын муж, хот, өөртөө засах орны 31 бүлэг ордын давсны үйлдвэрлэлийн хөгжлийн тойм байдлыг авч үзжээ. Энэ нь тэдгээр газрын давсны үйлсийн хөгжилтийн түүхийг тусгайлан судалсан судалгааны бүтээл юм.

Хятадын эрдэмтэн Фан Юйжин “Сайшаалт ерөөлтийн дунд үеийн Жартайн давст нуурын үйлдвэрлэл”¹², Лянхуа “ДИУ-ын эхэн үеийн албан давсны худалдаачны дүрмийн өөрчлөлт хийгээд түрээсийн тогтолцоо”¹³ зэрэг эрдэм шинжилгээний өгүүлүүд хэвлэгджээ.

Эдгээр судалгааны бүтээлээс үзэхэд судлаачид Сайшаалт ерөөлтийн үеэс хойших үеийн давсны асуудалд голчлон анхаарсан байна. Харин Чин улсын эхэн үеийн давсны судалгаа харьцангуй бага байх ажээ. Ялангуяа, Алшаа Хошууд хошууны давсны үйлдвэрлэл, тухайн үеийн удирдлага зохион байгуулалт, албан тушаалтнууд, цалин хөлс, бүрдүүлсэн тогтолцоо, ажилчид, жинчид, тээвэрлэлт, борлуулалтын чиглэл, хэмжээ далайц, албан татвар гэх мэт тодорхой асуудал, нарийн ширийн зүйлсийн талаар судалсан нь хомс, судалгаа харьцангуй дутмаг ажээ.

Судалгааны байдлаас үзэхэд сүүлийн 20 гаруй жилийн турш БНХАУ-д давсны бодлого, үйлдвэрлэлийн түүхийн асуудал судлаачдын анхаарлыг татаж, нэлээд олон ном бүтээл хэвлэгджээ. Энэ нь БНХАУ-д давсны түүхийн судалгаа улам өргөжин тэлж байгааг харуулж байна. Гэвч судлаачдын дийлэнх нь Хятад газарт холбогдох сэдвийг сонгон судалсан учир Монгол орны давсны түүхэнд хамаарах судалгаа харьцангуй цөөн ажээ. Судалгааны баримтаас харахад Монголын давсны түүхийн судалгаа 1980-аад оноос эрчимжиж эхэлсэн ба зарим судалгааны бүтээлүүд хэвлэгдэн гарчээ. Гэсэн хэдий ч Өвөр Монголын баруун

⁹ 梁丽霞；(2009)，《阿拉善蒙古研究》，北京：民族出版社。

¹⁰ 王泽民；(2007)，《杀虎口与中国北部边疆》，呼和浩特：内蒙古大学出版社。

¹¹ 唐仁粤；(1997)，《中国盐业史·地方编》，人民出版社。

¹² 方裕谨；(1991)，《嘉庆中期商办吉兰泰盐务述论》，历史档案 (02)，93-101。

¹³ 梁华；(2001)，《民国初期专商引岸制度改革与寻租》，江西社会科学，№4，45-52。


хойд орон, түүний дотор Алшаа Хошууд хошуунд холбогдох судалгаа нэн хомс буюу бараг судалгаа хийгдээгүй гэж хэлж болно. Тиймээс Чин улсын үеийн давсны үйлдвэрлэлийн үйл хэргийг Алшаа Хошууд хошуу зэрэг орон нутгийн жишээн дээр тулгуурлан судлах, холбогдох сурвалж баримтыг судалгааны эргэлтэд оруулах шаардлага судлаачдын өмнө зүй ёсоор тулгарч байна.

Алшаагийн Хошууд хошуунд хэрэгжүүлсэн Чингийн төрийн давсны бодлогын мөн чанар нь төрийн эрх ашгийг ямагт эн тэргүүнд тавьж байсан нь судалгаанаас тодорхой харагдаж байна.

Нэг. Алшаагийн хошууд хошууны давсны орд газрууд. Одоогийн БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны томоохон аймгийн нэг нь Алшаа аймаг билээ. Түүний засаг захиргааны төв нь Баян хот юм. Алшаа аймаг нь “Алшаа зүүн хошуу”, “Алшаа баруун хошуу”, “Эзнээ хошуу” гэсэн гурван хошуунаас бүрддэг. Тус аймаг нь 2000 оны байдлаар 199,279 хүн амтай бөгөөд үүнээс хятад үндэстэн 140,900 буюу (71.79 %), монгол үндэстэн 44,630 буюу (22.74 %), бусад үндэстэн 10,749 (5.46 %) байна. Алшаа зүүн, баруун хоёр хошуунд хошууд угсаатан, Эзнээ хошуунд торгууд угсаатан монгол үндэстний гол цөм нь болдог.

Алшаагийн хошууд хошуу бол давсны ордоор бялаг нөөцтэй газар орны нэг билээ. Чин улсын түүхэнд холбогдох газрын зургуудад Алшаагийн хошууд хошууны давсны орд газруудыг тодорхой тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, эдүгээ БНХАУ-ын төв музейд хадгалагдаж буй Алшаагийн Хошууд хошууны газрын зургийг дурдаж болно. Тус газрын зураг нь Герман улсын Үндэсний музейгээс олджээ. Энэхүү газрын зурагт Алшаагийн хошууд хошууны нутаг дахь давсны орд газруудыг маш тодорхой тэмдэглэсэн нь Чин улсын үеийн Алшаагийн хошууд хошууны давсны орд газруудыг нарийвчлан судлахад чухал эх сурвалжийн нэг болно.

Энэ газрын зурагт Алшаагийн Хошууд хошуун дахь давсны орд газруудыг тэмдэглэжээ. Тухайлбал, *Цагаанбулаг, Бор, Нарийн хаг, Загт, Ходой, Баяндалай, Улааны давст нуур, Тунах, Баянбулаг, Нуурт булаг, Яварай, Жороо гүүт, Тагва, Жартайн давсан нуур* зэргийн орд газруудыг тэмдэглэсэн байна. Эдгээр давсны орд газруудын зарим томоохон, гол орд газруудын тухай товч өгүүлье. Үүнд:



Зураг № 1. БНХАУ-ын Бээжин хотын төв музейн сан хөмрөгт хадгалагдаж Алшаагийн Хошууд хошууны нутгийн зураг

1. *Жартайн давст нуурын орд*. Энэ нуурыг бас Баянжартайн давст нуур гэдэг байна. Алшаа хошууны хамгийн том бөгөөд алдартай давст нуур төдийгүй, Азийн дотоод эх газрын томоохон давст нуурын нэг юм. Английн судлаач Паркер XIX зууны сүүлээр эл нуурын талаар, “Сүүл үе хүртэл давсны монополь хүчний ширүүн өрсөлдөгч нь Монгол нутгийн Жилэнтэй (吉兰泰-jí lan tai) нуурын давс байсан ба нэгэн цагт Алшаагаас Шар мөрний дагуу орших Хятадын төв хэсгийн нутагт өргөн нэвтэрч байв” хэмээн тодорхойлсон байдаг.¹⁴ Тус нуур нь Алшаа хошууны дунд хэсэгт байрладаг бөгөөд Жартайн давст нуураас баруун

¹⁴ Parker, E. H. (1899). The Chinese salt trade: An opening for British enterprise. *The Economic Journal*, 9 (33), т. 120

өмнө Хол дахиныг тогтоогч хороо (定远营-ding yuang ying) хүртэл 110 км, зүүн хойш Дэн көү (登口-deng kou) хүртэл 120 км, зүүн өмнө тийш Нинься хүртэл 180 км зайд байрлах ба хойд зүгт Их Хүрээ хүрэх их замтай байсан ажээ. Газрын байр байцын хувьд Алшаадаа хамгийн нам доор буюу далайн төвшнөөс 1031 м өндөрт оршдог. Нуурын орчим тойрны газар нь тэр чигтээ хужирлаг тул өвс, мод ургадаггүй ба тариалан эрхлэх боломжгүй юм. Уг давст нуурын байр байдлыг тодруулан өгүүлбээс: Хэлбэр, хэмжээний хувьд тус нуур нь Жартай багийн хэмжээнд байрлах ба хэлбэр дүрсийн хувьд зууван, талбай нь зүүнээс баруун тийш 10 км, өмнөөс хойш 37.5 км, эргэн тойрны 75 км гаруй талбайг хамарна. Давсны тухайд өөрөө ургадаг, сайн чанарын амттай давс гарах бөгөөд давс ургах талбай нь зүүнээс баруунш 10 км, өмнөөс хойшоо 25 км, бараг 500 гаруй км² газрыг хамардаг хэдий ч давс олборлох талбай нь 150 км² хүрэхгүй хэмжээтэй ажээ.¹⁵ Давс олборлох арга нь эхлээд төмөр царил, өрмөөр давсан бүрхүүлийн дээд давхаргыг хагалсны дараа төмөр хүрээр шавар шороог хусаад, дахин өрөмдөж доод давхаргын давсыг хагалж авдаг байна. Дараа нь нэрэл (малтах багаж) ашиглан шигшин угаасны дараа дахин урт бариулт шүүрээр шүүж, цэвэр давс гаран авдаг байжээ. Давс олборлох ажиллагаа цаг хугацааны хувьд ихэнхдээ хавар 3-5 сар, намар 8-10 сарын хооронд явагдах бөгөөд зун бороошиж, өвөл газар хөлдөх тул ажиллах боломжгүй болдог байна.¹⁶ Хавар, намрын улирал нь цаг агаарын хувьд таатай, нуурын ус багасахын дээр цагаан өнгөтэй болж хатан, давс олборлоход тохиромжтой болдог ажээ. Давсны ордын үе давхаргын хамгийн дээд хэсгийг давсан бүрхүүл гэж нэрлэх ба түүний зузаан нь 30 см орчим байх бөгөөд хужир, элс, бусад зүйлтэй холилдсон тул хүнсэнд хэрэглэх боломжгүй юм. Давсан бүрхүүлийн доор шавар, шороон давхарга байх ба түүнээс доошлоод сая цэвэр давс гардаг ба гүний хэмжээ нь 150-180 см, хамгийн гүндээ 3 метр гаруй хүрнэ. Нуурын хамгийн гүн хэсэгт дөрвөлжин хэлбэртэй талст байдгийг нутгийн улсууд “Давсан үндэс” хэмээдэг байна. Давс олборлож дууссаны дараа хэдэн сар өнгөрөхөд нуурын шавар шороо цэвэршиж, ус нь тунгалаг цэнхэр болж, улмаар ургасан давс нь цас мэт цайвалзан, жилийн дараа гэхэд дагшран дүүрдэг ажээ. Улмаар дахин нэг жил өнгөрөхөд олборлох боломжтой шинэ давс гардаг бөгөөд үүнийг байгаль эх аяндаа бий болгодогт энэхүү давст нуурын өгөөж баян онцлог оршино.¹⁷ Жартай нуурын давсыг Дэн көү хүртэл тэмээгээр ачиж хүргээд цаашаа хуурай болон усан замаар дамжуулан тээвэрлэдэг байжээ.¹⁸

2. Цагаанбулагийн давст нуур. Тус нуур бол Хол дахиныг тогтоогч хорооноос (ding yuang ying) баруун өмнөш 120 км, Жунвэй (中卫-zhong wei)-ээс хойш 130 км, Алаг уулаас (贺兰山-he la shang) зүүн хойш 150 км, Ниньсягаас баруун хойш 160 км зайд байрлах бөгөөд Алшаа хошуундаа хоёрт орох алдартай

¹⁵ 《阿拉善左旗档案馆馆藏档案》，101-0004-0080-0175。

¹⁶ 陈国钧；(1987)，《西蒙阿拉善旗社会》.，朝格图整理，《阿拉善盟旗志史料》，呼和浩特：内蒙古社会科学院印刷厂。

¹⁷ 苏雅拉图；(2016)，《阿拉善和硕特蒙古文历史档案》（抄件），远方出版社，第1册，412页。

¹⁸ 苏静远，王华记；(1992)，《磴口地区历史上的盐务》，《磴口县文史资料》，（第九辑）内部印刷，第35页。

давсны орд юм. Нуурын давс нь амт чанар сайн, хөхөвтөр өнгөтэй тул хөх давс хэмээнэ. Тус ордын байдлын тодорхойлбол: Цагаанбулаг багийн нутагт байрлах ба зууван хэлбэртэй, нуурын талбай нь 16.6 км², нуурын хүрээний урт 20 км гаруй үргэлжлэх бөгөөд давс ургах талбай нь 13.3 гаруй км² ажээ. Давс олборлохдоо бүх нуурт адилхан нэг талбайг таван жилийн турш ашигласны дараа талбайгаа сэлгэх байдлаар ажилладаг уламжлалтай. Харин нуурын зүүн өмнөд хэсгийн хэдэн арван км хэмжээтэй давсыг хөнддөггүй ба эрт цагт тэр хэсэгт давс малтахад улаан ус гарсанд монголчууд бурхан сахиусны цус хэмээн малтахыг цээрлэсэн домогтой. Давсны давхарга нь 18-30 см зузаан, давсны гүн нь 0.9-1.8 метр, хамгийн гүндээ 2.1-2.4 метр хүрдэг байна. Эхлээд төмөр өрмөөр нуурын дээд талын хатуу бүрхүүлийг хагалбал давстай ус нь харагдана. Төмөр арчуураар хусаж, дараагаар нь урт бариулт төмөр шанагаар давсаа нуурын гүвээнд шүүж гаргаад нар салхинд хатаасны дараа, давсан мөхлөг болдог аж. Давсыг ихэвчлэн хавар, намрын улиралд олборлоход тохиромжтой ба өвөл цаг уур дулаан байвал мөн давс шүүж болдог байна. Харин зуны цагт хур борооноос үүдэн ажиллахад хэцүү байдаг ч сүүлийн 2-3 жилд баруун хойд орны уур амьсгалд өөрчлөлт гарснаас болж, давс олборлох хугацаа нь тухайн жилийн 9 сараас дараа жилийн 6 сарыг дуустал явагдах болж уртассан төдийгүй давс олборлох хэмжээ нь ч тэр хэрээр нэмэгджээ. Тухайн жил давс олборлосноос хойш 3 жилийн дараа нуурын давс дахин ургаж гүйцдэг, түүнээс хойш дахин 2 жил өнгөрөхөд шүүж авах боломжтой болдог байна.¹⁹

3. *Ходой (Ходон) нуур*. Тус давсны орд нь Цагаанбулагийн давст нуурын зүүн хойно байрлах ба Цагаанбулаг, Тунах, Улааны нууртай адил түрээсээр ашиглуулж ирсэн байна. Зүүн тийш Хол дахиныг тогтоогч хорооноос 120 км, өмнө зүг Цагаанбулагийн нуураас 150 км, хойш Жартайн нуураас 100 гаруй км зайд байрлах ба Алшаа хошуундаа гуравт орох орд болох алдартай нуур юм. Хэлбэрийн хувьд эл нуур зууван хэлбэртэй, Хөөвөртийн багийн нутагт оршино. Нуурын талбай нь зүүнээс баруунш 3 км, өмнөөс хойш 10 км, нуурын хүрээний урт 16 км, давс гарах талбай нь уртаашаа 2.5 км, өргөөшөө 8-9 км, Жартайн нууртай харьцуулахад нэлээд зөрүүтэй хэдий ч бусад нуурын адил олборлон ашиглаж ирсэн байна. Цагаанбулагийн ордтой адилхан 5-6 жилд нэг удаа талбайгаа сэлгэж ашигладаг ажээ. Энэхүү нуурын давсан бүрхүүл нь 12-24 см зузаан, давсны гүний хэмжээ нь 60-120 см, хамгийн гүн нь 1.5-1.8 метр хүрдэг аж. Давс олборлохдоо эхлээд төмөр өрмөөр 24-30 см зузаан давсан бүрхүүлийг хагалаад, дахин 3 см орчим шавар шороог авч цэвэрлэсний эцэст цэвэр давс нь гардаг байна. Үргэлжлүүлэн төмөр малтуураар усыг нь шигшиж ариутган, төмөр шанагаар шүүгээд 3-5 хоног хатааж хуурай давс болгон олборлодог. Давс боловсрох, шүүх цаг нь бусадтай адил ихэнх үед хавар, намрын улиралд тохирох ба хэрэв өвөл нь өнтэй дулаахан, зун нь хур бороо багатай бол олборлох нь бий. Ходон нуураас байгалиас ургасан хөх давс гардаг бөгөөд малтаж дууссаны дараа 3-4 жилд малтлагын талбай дахин дүүрдэг ч давс нь бүрэн боловсроогүй, цагаан

¹⁹ 马成浩; (1943), 《边疆通讯》, 第9期, 第7页。

өнгөтэй, амархан хэмхэрдэг байна. Харин бүдүүн мөхлөгтэй хөх давс болох хүртэл 8-9 жилийг зарцуулдаг тул энэ хугацааг баримтлан ашиглахыг эрхэмлэдэг уламжлалтай бөгөөд чингэх аваас давсны нөөц шавхагдашгүй юм.²⁰

4. *Яварайн давст нуурын орд*. Тус орд нь Ланьжоу-гаас хойшоо орших, түрээсээр малтуулдаг 13 нуурын нэг бөгөөд Цагаанбулагийн нуураас баруун хойш 280 км, зүүн өмнө зүгт Минцэнээс 100 км зайд байрладаг. Алшаа хошуундаа дөрөвт орох давст нуур юм. Энэхүү нуур нь хөх давстай, амт чанарын хувьд тансаг, ургац арвинтай, байгаль эхийн бүтээсэн бас нэгэн онцлог орд юм. Яварай нуурын давс боловсрох, олборлох арга нь өмнөх нууруудтай адилхан ба уг ордын зарим онцлогийг дурдвал: Яварай багийн нутаг дэвсгэрт байрлах ба хэвтээ зууван хэлбэртэй, 15 гаруй км хүрээний хэмжээтэй, олборлох талбайн хувьд чөлөөтэй бөгөөд 7-8 жилд нэг удаа газар сэлгэн малтаж ашигладаг байв. Яварай нуурын орд нь жилийн бүх улиралд малтаж болдгоороо онцлог төдийгүй, давс боловсрох цаг хугацааны хувьд Ходон нууртай, олборлох арга барилын хувьд Цагаанбулаг, Ходон нууртай адил юм.²¹

5. *Улааны давст нуур*. Тус нуурын давсны өнгө нь улаан тул ийнхүү нэрлэсэн ба түрээслэн олборлуулж ирсэн 13 давст нуурын нэг төдийгүй амт чанарын хувьд Цагаанбулагийн давснаас ч сайн ажээ. Байршлын хувьд Цагаанбулагийн нуураас өмнө зүг 55 км, зүүн өмнө зүгт Хүрэнээс 55 км, зүүн хойш Хол дахиныг тогтоогч хорооноос 150 км зайд орших бөгөөд Алшаа хошуундаа тавдугаарт ордог орд юм. Давсны ордын байдлын тоймлон танилцуулбал: Цагаанбулаг багийн нутагт байрлах ба зууван хэлбэртэй, нуурын хүрээний урт 2-2.5 км, давс гарах талбай нь ойролцоогоор 1 км болно. Давс олборлолтын хэмжээ ба ашиглах цаг хугацаа хэдийд байх зэрэг нь хур тунадаснаас шалтгаалах ба хэрэв хур бороо тэгш бол давсны ургалт, гаралт арвин, тийм бус бол гаралт бага байдаг аж. Давс олборлолт гол төлөв жил бүрийн 5-10 сарын хооронд явагддаг байна. Борооны дараа нар гарвал давс аажмаар ургах ба нуурын ус их байвал давс тогтолгүй усанд уусдаг. Хэрэв хэт бага устай бол давс ургаж чадахгүй тул нуурын ус 12 см хэмжээтэй бол давс ургахад хамгийн тохиромжтой байдаг ба 7-8 өдрийн дотор ургадаг байна. Тиймээс давс ургасан үед урт бариулт шанагаар шүүж аваад нар, салхинд хатаавал мөхлөг болдог, хэрэв хугацаандаа амжиж шүүхгүй бол нууран дээгүүр давсан бүрхүүл тогтон хатуурдаг байна.²²

6. *Тунхугийн давст нуур*. Тус нуураас цагаан давс гарах тул “Цагаан давст нуур” гэж нэрлэдэг байна. Цагаанбулагийн нуурын зүүн өмнө байх Улаан, Ходон зэрэг нууруудтай адил түрээслэн ашиглуулж малтуулдаг нуур ажээ. Нуур нь зүүн өмнөш Жунвэй-гээс 30 км, хойд талдаа Цогт хүрэнээс 50 км зайд байрлана. Давсны чанар сайнгүй, гашуун амттай дул Алшаа хошуундаа хамгийн доод зэрэглэлийн буюу зургаад ордог бөгөөд их төлөв Улааны давст нууртай төслөг

²⁰ 《西北论坛》，(1947)，创刊号，第32页。

²¹ 苏雅拉图；(2016)，《阿拉善和硕特蒙古文历史档案》（抄件），远方出版社，第1册，412页。

²² 陈国钧；(1947)，《经济汇报》，9(11)，第61页。

юм. Тус орд нь Тунху багийн нутагт байрлах ба мөн л зууван хэлбэртэй, 5 км орчим хүрээний урттай, 3-4 газарт давс олборлох боломжтой ажээ. Эл нуураас давс олборлохдоо ажилчид тус бүрдээ хувьдаа татаал гаргаж, 3-4 сард ус татдаг бөгөөд салхи, наранд ээгдэж 7 хоног өнгөрөхөд давсан мөхлөг болдог ба энэ нь далайн давс боловсруулах аргатай адил болно. Давс шүүх ашиглах тохиромжтой үе нь жил бүрийн 3-9 сарын хооронд байна.

7. *Мөнхцагаан, Мөнх-Улаан, Хар давст нуурын бүлэг орд.* Мөнхцагаан давст нуур (大鼓海-da gu hai), Мөнх-Улаан давст нуур (角鹿海), Хар давст нуур (梧桐海-wu tong hai) гэх гурван бүлэг нуур нь Яварай нуурын баруун өмнө талд, Шиндан хотын арын Лун уулын хойд хэсэгт, ойролцоогоор 150 гаруй км талбай эзлэн оршино. Тус гурван нуурын олборлолтын талбай тус бүрдээ 5 км, давс нь цэвэр байгаль дээрээ бүрэлдэн буй болсон, ургац арвинтай, давсан бүрхүүлийг хагалбал шууд цэвэр давс гардаг онцлогтой.

Дээр дурдсан давсны орд газруудаас үзэхэд Алшаагийн Хошууд хошуу нь давсны арвин баялаг нөөц бүхий олон давст нууруудтай болох нь тодорхой харагдаж байна. Эдгээр орд газруудаас давс олборлох, ашиглах бодлого, үйл хэрэг нь олон зууны түүхэн уламжлалтай тул архивын данс хараа, түүхийн сурвалж бичигт тэмдэглэгдсээр иржээ.

Алшаагийн Хошууд хошууны давст нуурын тархалт байршлын онцлог ба борлуулалтын орон зайг үндэслэн үндсэнд нь өмнөд ба умард хэсгийн давсны орд хэмээн хоёр хэсэгт хувааж болно. Өмнөд хэсгийн давст нуурын олборлолт өмнө зүг Ганьсу рүү гол төлөв чиглэж байсан бол Умард хэсгийн давс нь Хатан голоор дамжин Шаньси хүрч байсан ажээ. Өмнөд хэсэг нь хуурай замаар Ганьсутэй, баруун талаараа Бадайн жаран, Зүүн талаараа Улаан бухын элс, баруун өмнө талаараа Тэнгэр элс, зүүн урд талаараа Алшаа уулаар хүрээлэгдэнэ. Давст нуур нь дээрх байгалийн саадуудын дунд хүрээлэгдэн оршдог тул гадагш тээвэрлэхэд хэцүү хүндрэлтэй аж. Машин тэргээр тээвэрлэх боломжгүй, тэмээн хөсгөөр л зөөж болдог онцлогтой байв. Харин хойд ордуудын хувьд зүүн хойд талд нь Хатан гол урсдаг тул олборлосон давсаа хуурай замаар Хатан гол хүргээд, цааш нь усан замаар зөөх боломжтой байсан юм.

Хоёр. Манж Чин улсаас Алшаагийн хошууд хошуунд хэрэгжүүлсэн давсны бодлого. Чин улсын эхэн үеийн төрийн давсны бодлого нь анхандаа Мин улсын үеийн давсны бодлогыг залгамжлан, үндсэндээ онцын өөрчлөлтгүй үргэлжлүүлсэн, Монгол хошуудын давсыг Хятад газар оруулж борлуулахыг хориглон хязгаарласан шинжтэй байв. Гэхдээ цагаан хэрмээс гадуурх Хятадын зах хязгаар нутгуудад давсны эрэлт хэрэгцээ маш их байсан бөгөөд гол учир нь Хятад газраас ирэх албан давс үнэтэй, нутаг орон алс хол, зам харгуй муутай тул тээврийн зардал нэмэгддэг, тэгээд ч бага хэмжээтэй ирэх албаны давс нь иргэдийн хэрэгцээг бүрэн гүйцэд хангаж чадахгүй байлаа. Ийм учраас энэхүү асуудлыг шийдэхийн тулд Чингийн төр Хятадын зах хязгаар бүс нутагт Монгол хошуудын давсыг далдуур, бага хэмжээгээр худалдаалах, борлуулахыг зөвшөөрөх

болсон байна. Үүний үр дүнд Хятадын зах хязгаар нутгийн ард иргэдийн давсны эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чадахаар болсон төдийгүй тэд заавал хятад мужаас ирэх үнэтэй давсыг авах шаардлагагүй болжээ.

Монгол хошуудын хувьд ч өөрсдийн нутгийн баялаг болох давсыг хятад иргэдэд зарж, түүнээс олсон ашгаараа амьдрал ахуйгаа тэтгэж байлаа. Иймээс хоёр талын ашиг сонирхол энэ цэг дээр огтлолцож байсан учир Чингийн төр болон Монгол хошууд давсыг нууцаар, сэм байдлаар бага хэмжээгээр Хятадын зах хязгаар нутагт оруулан борлуулж, зах зээл дээрх бодит эрэлтийг ханган нийлүүлэх болсон юм. Энэ үеийг бүхэлд нь авч үзвэл Алшаа зэрэг монгол хошуудад явуулж байсан Чин улсын давсны бодлого нь түүхэн уламжлалд тулгуурласан, урьдын бодлогыг хэвээр хадгалсан, даган дуурайсан шинжтэй байсан юм.

Чин Улсын үед Алшаа хошууны цэвэр давс гардаг 14 нуураас давс олборлон ашиглаж байсан ба эдгээр нуурын давсыг улаан, хөх, цагаан гэсэн гурван төрөлд хувааж, үүнийг иргэд “Улаан давс”, “Боомтын давс”, “Жартайн давс” гэх зэргээр нэрлэдэг байв. Алшаа давсыг анх 1736 онд олборлосон гэж зарим судлаачид²³ үздэг ч Алшаагийн зүүн хошууны архивын сан хөмрөг дэх баримтыг үндэслэвэл, наанадаж чин ван Абуу 1724 онд Хөх нуур руу нүүж, 1730 онд Алшаад буцаж ирсний дараа жилээс²⁴ буюу 1731 оноос давс олборлож эхэлсэн бололтой байна. Тус баримтад “Шаньси мужийн Хөфан зэрэг 11 жөү, шянь Найралт төвийн 8-р он буюу 1731 онд Алшаагийн давсыг худалдан авч, хэрэглэж байсан” тухай тэмдэглэжээ. Үүнийг үндэс болгож Алшаагийн давст нууруудаас 1731 оноос эхлэн албан ёсоор давс олборлож эхэлсэн гэх саналыг бид дэвшүүлж байна. Тэрчлэн цаашид өөр бусад архивын баримт мэдээг олж чадвал Алшаа хошуунаас давс олборлож эхэлсэн он цаг илүү урагшлах боломжтой юм. Ямар боловч Чингийн төр 1697-1736 оныг хүртэл ерөнхийдөө Монгол хошуудын давсыг Хятад газарт худалдаалан борлуулахыг хориглосон шинжтэй бодлого баримтлан явуулж ирсэн байна. 1736 оныг хүртэл Монгол хошуудын давсыг Хятад газар худалдаалахыг Чингийн төрөөс хориглож ирсэн нь Хэдун (河东-he dong)-ы давсны зах зээлийг хамгаалах бодлоготой холбоотой байжээ. Хэдун-ы давсны зах зээл нь Чингийн үеийн албан давсны 14 зах зээлийн нэг байсан бөгөөд давс худалдан борлуулсан ашиг орлого нь улсын сан хөмрөгт ордог байсан тул тийн хамгаалдаг байсан юм.

Чингийн төрийн дээрх уламжлалт бодлого 1736 оноос өөрчлөгджээ. Тус өөрчлөлтөөр гол нь Хошууд зэрэг хавь ойрын Монгол хошууны давсыг зөвхөн хуурай замаар тээвэрлэж, Шүрэгийн боомтоор дамжуулан, Шаньси мужийн умард хэсэгт нэвтрүүлж худалдаалахыг албан ёсоор зөвшөөрсөн юм. Энэ бол давсны талаарх уламжлалт бодлогод гарсан томоохон өөрчлөлт хувьсал байв. Чингэж хуурай замаар давс тээвэрлэн оруулж худалдаалахыг зөвшөөрсөн нь Чингийн төр Шүрэгийн боомтоор дамжуулан монгол давснаас алба татвар хурааж, улсын

²³ 牧人：《阿拉善盟盐业志》，呼和浩特：内蒙古人民出版社，2007年，42页。

²⁴ 《阿拉善左旗档案馆馆藏档案》，全宗号：101-0003-0045-0118。

төсвийн орлогыг бүрдүүлэхтэй холбоотой байлаа. Өөрөөр хэлбэл, далдуур, хууль бусаар монгол хошуудын давс Шаньси мужид зарагдах нь улсын төсөв бүрдүүлэхэд тус нэмэргүй, түүнээс алба татвар авах боломжгүй байсан тул тийнхүү албан ёсны болгосноор Чингийн төр Алшаа зэрэг хошуудын давснаас алба татвар хураах боломжтой болсон байна. Тийнхүү энэ үеэс Чингийн төр Алшаа давсанд хяналт тавих, албан худалдаачдаар дамжуулан давс тээвэрлэх, борлуулах үндсэн үүргийг гүйцэтгүүлж болсон юм. Үүнээс онцгойлон борлуулалтын хэргийг голчлон албаны худалдаачид гүйцэтгэж байлаа. Төрийн хяналт дор албаны худалдаачдаар дамжуулан давс борлуулах энэхүү бодлого нь Чингийн төр, давс худалдаалах эрхийг ганцаар эзэмших, худалдаачин элсүүлж, давсны тэмдэгтээр дамжуулан давсны борлуулалтын зах зээлийг тодорхойлох, худалдан борлуулах давсны хэмжээ, давсны татварыг тогтоох зэрэг боломжийг олгож байсан юм. Давсны татвар нь улсын төсвийн орлогын чухал эх үүсвэр болж байсан тул зарим үед гадаадаас өр зээл авахад барьцаа болгох, цэргийн нэмэгдэл зардал шаардагдахад гол тулгуур болгох явдал гарч байв.

1736 онд Шаньси мужийн захирагч, цагдан байцаагч түшмэл Шилинь (石麟-shi lin) Шүрэг боомтын давсны татварын хэргийг шалгаад, Шаньси-гийн умард хэсгийн шороон давсны хүрэлцээгүй байдлыг шийдвэрлэх үүднээс Шүрэгийн боомтод зохих татвар тушаагаад хуурай замаар Монгол хошуудаас давс тээвэрлэн, Шаньси мужийн умард хэсгийн зах зээлд нийлүүлэх санал гаргаж, хаанд айлтгасанд Чингийн төр зөвшөөрчээ²⁵. Энэ бол Алшаагийн хошууд хошуу тэргүүтэй Монгол хошуудын давсыг Хятад газрын зах зээлд худалдан борлуулахыг анх удаа албан ёсоор зөвшөөрсөн хэрэг байлаа. Ингэснээр Халзан толь, Жартай зэрэг Алшаагийн Хошууд хошууны хойд хэсгээс олборлосон давсыг монгол, хятад иргэд тэмээн жингээр, хуурай замаар тээвэрлэн Бугат, Сюйань, Нинься, Шаньси-гийн умард нутаг руу ямар нэгэн хориг хязгаарлалтгүйгээр чөлөөтэй худалдах болов.

Монгол хошуудын давсыг хятад газарт худалдаалахыг Чингийн төр зөвшөөрсөн нь дараах шалтгаантай. Үүнд:

1. Давсны хууль бус наймааг таслан зогсоох. 1736 оныг хүртэл монгол хошуудын давсыг тэмээн жинчид хятад газрын иргэдтэй харилцан тохиролцож гурил будаа, хэрэгцээт бараагаар солилцож, жинчдээс худалдаж авсан давсаа хятад худалдаачид болон иргэд Шаньси-гийн умард хэсэг рүү ямар нэгэн албан татвар төлөхгүйгээр хулгайгаар нэвтрүүлж, хууль бусаар худалдаалж ирсэн түүхтэй. Энэ байдлыг Шаньси мужийн цагдан байцаагч түшмэл Шилинь олж мэдээд, Монгол хошуудын давсыг Шүрэгийн боомтод төвлөрүүлэн татвар тушаасны дараа Хятад газарт худалдан борлуулахыг зөвшөөрөх замаар давсны хууль бус наймааг таслан зогсоохыг оролдсон юм.
2. Шаньси-гийн умард хэсэгт үүсээд байсан давсны хомсдолыг арилгах. Шаньси-гийн умард хэсгийн хүн ам өсөхийн хэрээр давсны эрэлт хэрэгцээ ч мөн дагаад өссөн бөгөөд үүнийг шороон болон албаны давс хангалттай хангаж чадахгүй байсны улмаас давсны хомсдол үүсээд

²⁵ 《清朝文献通考》，卷29，《征榷四》，杭州：浙江古籍出版社。

байжээ. Иймээс Чингийн төр дээрх хомсдолыг арилгахын тулд Монгол хошуудын давсыг тус бүс нутагт худалдан борлуулахыг зөвшөөрсөн аж.

3. Улсын сан хөмрөгийг татварын орлогыг өсгөх аргаар нэмэгдүүлэх. 1736 оноос өмнө Монгол хошуудын давс хууль бусаар Шаньси-гийн умард хэсэг рүү нэвтэрч байхад Чингийн төр түүнээс ямар ч татвар авч чаддаггүй байсан бөгөөд хууль ёсны дагуу дээрх арга замаар Хятад газарт Монгол давс худалдаалахыг зөвшөөрснөөр түүнээс татвар хураамж авах боломж бүрдэж, улсын санхүүгийн орлого тодорхой түвшинд өсөх эерэг талтайг Чингийн төр анзаарсан байна.

1757, 1759 онуудад Шаньси-гийн өмнөд хэсгийн Юнчэн хотын Жечи давст нуур үерт автаж, давсны нийлүүлэлт буурснаар Шаньси-гийн иргэдийн дунд давсны хомсдол нүүрлэв. Ордос болон Цахарын монгол хошуудаас хуурай замаар давс тээвэрлэн Шаньси муж руу нийлүүлж байсан хэдий ч иргэдийн дунд үүссэн давсны эрэлтийг бүрэн гүйцэд хангаж дийлэхгүй байлаа. Манжийн төр энэхүү давсны хомсдолыг шийдэх арга зам эрэлхийлж байв. Хошууны эрх баригчид ч энэ боломжийг алдахыг хүсээгүй юм. Үүнийг архивын доорх баримт илтгэн харуулж байна. Тухайлбал, 1759 онд Алшаагийн Хошууд хошууны засаг ноён Лувсандорж хошуунаасаа олборлосон давсыг усан замаар тээвэрлэн Хөх хот, Бугат зэрэг газарт тээвэрлэн борлуулж, хошууны сан хөмрөг болон ард иргэдийнхээ аж амьдралыг тэтгэхийг зорьж доорх гуйлтыг Чингийн төрд өргөсөн байдаг. Үүнд:

“Давсыг худалдаж зүдэрсэн иргэдэд тус болохыг гуйх нь: Манай хошууны Алшаа уулын зүүн хойд талд давст газар нуур нэгжгээд буй бөлгөө, өргөнөөр зуу илүү нум турш, уртаараа хоёр зуун нум турш, Нинься фу-гийн Пинлү шянь-аас гурван зуу гаруй газар зайтай. Давс худалдаж өгөх, авах дор газар хол бөгөөд говь, элс нь их хэмээж давст нуурт ирж харилцан өгч, авалцах чадвар үгүйн тулд давст нуурын нэр байвч худалдан авах хүнгүй. Урьд дорд иргэд тэмээ, үхэр ачиж бага сага худалдаж байдаг бөлгөө. Эдүгээ хэдэн жил бороо хур чухаг болоод ардын аж төрөх мал цөөрч зүдрээд хагас нь ядуу болоход хүрэв. Гуйх нь, давст нуур Хатан голд ойр тул манай хошуунаас арвин онгоц үйлдэж давсыг хөлгөнд ачин Хатан голыг уруудуулж, Хөх хотын харьяа Саальчид, Бугат зэрэг газар хүргэж худалдваас ихэд тус болмуй. Манай хошуунаас хэрэг явдалд шуурхай үнэнч түшмэл гаргаж захируулан, хэрэг учир гаргахгүй байхыг хичээе. Ингэж шийдэж болох эсэхийг Их журганаас тогтоож өгөхийг гуйж өргөв” гэсний хариуд, Чингийн төрөөс *“Шинэ ёс гаргасан чинь их сайн, ийм журам гаргаваас танд их тустай билээ. Давсыг даруй зөөтүгэй”*²⁶ хэмээн зөвшөөрчээ.

Чингийн төрөөс Алшаагийн Хошууд хошууны давсыг усан замаар Хөх хотын Хэ көү гарам хүртэл тээвэрлэхийг зөвшөөрсөн түр цагийн арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлэв. Энэ нь Алшаагийн хошууд хошууны давсыг усан замаар зөөвөрлөх үйл ажиллагааны эхлэл, Алшаа Хошууд хошууны давсыг усан замаар тээвэрлэж, нэр дурдсан боомтын гаднах хотуудад худалдаалахыг төрөөс зөвшөөрсөн анхны тохиолдол байлаа. Үүгээр Алшаагийн давсыг Шүрэгийн боомт хүртэл хуурай замаар зөөж, улмаар усан замаар Хэ көү хүргээд, тэндээс Хөх хот, Тогтох, Бугат зэрэг газруудад тээвэрлэн

²⁶ 《阿拉善左旗档案馆馆藏档案》，全宗号：101-0003-0012-0029.

хүргэж, худалдан борлуулах боломжтой болсон юм. Тийнхүү 1760 оноос эхлэн Алшаагийн Хошууд хошууны давсыг усан замаар Хөх хотын Хэ көү хүргэдэг байнгын шинжтэй тээврийн зам нээгдсэн түүхтэй. Энэхүү арга хэмжээ нь зөвхөн хуурай замаар тээвэрлэн худалдаалах бодлогыг дахин нэг шат ахиулж, усан замаар тээвэрлэх нь тээврийн зардлыг хэмнэхийн сацуу цаг хугацаа хожих давуу талыг олгож, давсны эрэлт, нийлүүлэлтэд сайнаар нөлөөлөв. Ингэснээр тус хошууны давст нуурын олборлолт, тээвэрлэлт, борлуулалт нэмэгдэж, ашиг орлого нь өсөж, давст нуурын баялаг эдийн засгийн эргэлтэд орж, үйл хэрэг нь өрнөн дэлгэрэх үүд хаалга нээгдсэн байна.

Усан замаар давс тээвэрлэхийг зөвшөөрснөөр Алшаагийн хошууд хошууны давст нуурын олборлолт, тээвэрлэлт өмнөх үеэс өссөн хэдий ч Шаньси-гийн умард хэсгийн давсны хомсдолыг хангалттай хэмжээнд арилгаж мөн чадахгүй байлаа. Энэ нь монголчуудын уламжлалт аж ахуй, зан дадалтай холбоотой бөгөөд монгол иргэд давс олборлох, тээвэрлэх ажилд төдийлөн хангалттай хэмжээнд идэвхийлэн оролцдоггүй байсан аж. Үүнийг нэг талаар эртнээс таван хошуу мал сүргээ өсгөн үржүүлж аж төрж, эх байгаль, газар нутгаа хайрлан хамгаалж, шүтэн биширч, зохицон оршиж ирсэн уламжлалтай; нөгөө талаар хөрөнгө мөнгө, ашиг орлого, эд баялгийг эрхэмд үздэггүй нүүдэлчдийн сэтгэлгээ зэрэг олон хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болно. Энэ нь нөгөөтэйгүүр хятад иргэд, худалдаачдад аятай боломж олгосныг хэлэх хэрэгтэй. Үүнтэй холбогдуулан дурдахад, 1759 онд Хүрээний сайд, ван Санзайдорж Манжийн хаанд мэдүүлсэн нэгэн бичигтээ, хятад худалдаачдыг тусгайлан байгуулсан худалдааны газарт худалдаа хийлгэхэд малтай унаатай хүн тэнд очиж хэрэгцээтэй юмаа худалдан авч болох боловч унаа малгүй хоосон ядуу хүмүүс олон буй нь явган нүцгэн явж дэлгүүр пүүстэй газарт хүрч чадахгүй тул хятад иргэдийг хошуу нутагт чөлөөтэй явуулж байя гэдэг саналыг Манжийн төрд илэрхийлсэн байх бөгөөд Манжийн төр Санзайдоржийн энэ саналыг ёсоор болгож, хятад худалдаачдыг хошуудаар явж худалдаа хийхийг зөвшөөрсөн байдаг. 1763 онд Чингийн төр Шаньси дахь давсны эрэлт хэрэгцээг хангах үүднээс Шаньси-гийн умард хэсгийн хятад худалдаачдыг давсны худалдаа эрхлэх зөвшөөрлийн бичиг авч, боомтоос гарч Алшаагийн Хошууд хошууны давсыг худалдан авч, борлуулахыг зөвшөөрсөн явдал болно. Манжийн төр Монгол газар нэвтэрч буй хятад иргэдийг түлш авах, гурил будаа наймаалах, давсны худалдаа эрхлэх, тариа тарих, хөлсний хөдөлмөр хийх болбоос нутгийн ноёдод бүртгүүлж, жил бүр нэг удаа тамгатай гэрч бичиг авч, боомтоор гарахдаа хянан байцаалгаж шалгуулдаг байхаар тогтоожээ. Энэхүү бодлогыг хэрэгжүүлснээр зөвхөн Алшаад гэхэд давсны олборлолт хэт ихэс ч, тээвэрлэн хадгалсан нөөц нь 2300 гаруй дан²⁷ хүрсэн мэдээ буй.

²⁷ 《阿拉善左旗档案馆馆藏档案》，全宗号：101-0003-0011- 0207。

1763 онд Шаньси-гийн Цагдан байцаах сайд Миндө Чингийн төрд айлтгал өргөсний дүнд, Шаньси мужийн 11 жөү, шянь-ий давсны худалдаачид зөвшөөрлийн тэмдэгт бичиг аваад Алшаа хүрч, давс худалдан авах боломжтой болсон байна. Улмаар Тэнгэрийн тэтгэсний 45-р он буюу 1780 онд хятад худалдаачдад боомтын доторх Датун, Шөүфэн зэрэг газарт Алшаа давсыг ачин борлуулах зөвшөөрөл олгожээ. Гэхдээ Чингийн төр Шаньси-гийн дунд болон өмнөд хэсэгт монгол хошуудын давсыг нэвтрүүлэхийг хориглосоор байсан бөгөөд зөвхөн Шаньси-гийн умард хэсгийн Датун, Шүөпин зэрэг газруудад монгол давс худалдан борлуулахыг зөвшөөрч байлаа. Давс худалдан борлуулах зах зээлд ингэж хязгаарлалт тавьж байсан нь мөн л Монгол хошуудын давс Хэдун-ы албан давсны зах зээлд цохилт өгч, сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлсэн хэрэг байв. Тиймээс Монгол хошуудын давс энэ үед ч хязгаарлан тогтоосон зах зээлийн орон зайн хүрээнд борлуулагддаг байдлаар, өсөх, буурах, нээгдэх, хаагдах зэргээр үргэлжилсээр байжээ. Энэ мэт нөхцөл байдал түүхэнд үе үе тохиолдсоор ирсний цаад учир шалтгааны талаар Монголын нэрт түүхч Д.Гонгор, “Нүүдэлчин малчид түүхийнхээ бүхий л үед суурьшил тариалангийн оронтой эдийн засаг-улс төр, соёлын харилцаатай явжээ. Нүүдэлчин ба суурьшмал ард түмний хоорондын жирийн харилцаа үе үе эвдрэлцэх, худалдаа арилжаа тасалдах явдал байсан нь энгийн санамсаргүй зүйл бус, эдийн засгийн үндэс, улс төрийн уг шаг бүхий байжээ”²⁸ хэмээн тэмдэглэсэн байдаг.

1782 онд Алшаа хошууны засаг ноён Лувсандорж Чингийн төрд дахин айлтгал өргөж, Алшаагийн Хошууд хошууны давсыг Шаньси-гийн дунд хэсэгт оруулан борлуулахыг хүссэнд зөвшөөрчээ²⁹. Энэ бол Хятад газрын давсны эрэлт хэрэгцээнээс үүдсэн шийдвэр байсан бөгөөд нөгөөтэйгүүр хятад худалдаачдын үйл хэргийг дэмжихэд чиглэсэн алхам байлаа. Урьд нь Алшаагийн давс Шаньси-гийн умард хэсгийн зах зээлд зарагдаж байсан бол 1782 оноос эхлэн Шаньси мужийн дунд хэсгийн Тайюань, Фэн жөү зэрэг “шороон” давс хэрэглэдэг бүс нутагт борлуулагдах болжээ. Тэр цагт Шаньси муж 9 фү, 10 жөү-тай байсны 5 фү, 7 жөү-гийн хэмжээнд Алшаа давс зарагдах болсноос энэхүү зах зээл хэр их тэлснийг харж болно. Ийнхүү Алшаагийн хошууд хошууны давс Шаньси-гийн дунд хэсгийн зах зээл рүү албан ёсоор нэвтрэн орж, Алшаа давс худалдан борлуулах зах зээл өргөжин тэлэв. Ингэснээр Алшаагийн хошууд хошууны давс Шаньси-гийн хойд хэсгийн Датун (大同-da tong), Шүөпин (朔平-shuo ping) болон Шаньси-гийн дунд хэсгийн Тайюань (太原-tai yuan), Фэн жөү (汾州-feng zhou), Нину фу (宁武府-ning wu fu), Баодэ жөү (保德州-bao de zhou), Шинь жөү (忻州-xin zhou), Дай жөү (代州-dai zhou), Пиндин жөү (平定州-ping ding zhou), Ши жөү (隰州-xi zhou), Ляо жөү (辽州-liao zhou), Чин жөү (沁州-qin zhou) зэрэг газарт худалдаалагдах болжээ. Үүнээс гадна боомтын гаднах Сюань Доалин-ы 6 тэнхимд Алшаагийн давс (归绥道所辖口外六厅) борлуулагдаж байсан бөгөөд Шаньси мужид нийтдээ 9 фү, 10 жөү байсны 5 фү, 7 жөү-д Алшаа давс зарагдаж эхлэв.

²⁸ Гонгор Д. *Халх товчоон*. II. УБ., 1978, т. 307

²⁹ 《阿拉善左旗档案馆馆藏档案》，全宗号：101-0003-0040-0119.

1786 онд Алшаагийн засаг ноён Ванчинбамбарын айлтгасан хүсэлт ёсоор Алшаагийн хошууд хошууны давсыг Алшаагийн Дэн көү-гээс Хатан голын усан замаар тээвэрлэн Шаньси-гийн дунд хэсгийн Чи көү гарам хүртэл тээвэрлэхийг зөвшөөрсөн шийдвэрийг Чингийн төр гаргасан байдаг. Энэ нь онцгой чухал шийдвэр байсан бөгөөд Чингийн төр урьд өмнө нь хэзээ ч Монгол хошуудын давсыг Хятад газрын гүнд усан замаар тийнхүү нэвтрүүлж байгаагүй юм. Чингийн төр уг бодлого, шийдвэрийг гаргасан нь нэгдүгээрт, Ванчинбамбар болон Тэнгэр тэтгэгч хааны хоорондын сайн харилцаа, Ванчинбамбарын Чингийн төрд эзлэх байр суурь, хоёрдугаарт, Шаньси-гийн дунд хэсгийн иргэдийн амт чанар муу “шороон” давсыг биш Алшаагийн амт чанар сайтай давсыг хэрэглэх хүсэл сонирхол нөлөөлсөн гэж үзэж болно. Энэхүү алхам нь Алшаагийн хошууд хошууны давсны усан тээврийн худалдааг ихээхэн ахиулж, Хатан голын дээд, доод урсгалын хооронд давсны тээвэр хурдацтай хөгжихөд ихээхэн түлхэц үзүүлэв. Тийнхүү давсны зах зээлийн хүрээ нь өргөжин тэлснээр Шаньси муж дахь Алшаа давсны борлуулалтын хэмжээ мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. 1786 оноос өмнө жил бүр 700 мянга орчим кг давсыг усан замаар тээвэрлэж байсан бол цааш Чи көү хүртэл тээвэрлэх болсноор жилийн хэмжээ 8.4 сая кг-д хүрч, тээвэрлэлт, борлуулалтын хэмжээ арав дахин өсжээ. 1792-1805 он хүртэл хугацаанд жил бүр 600 онгоц давс тээвэрлэх болжээ.

Усан замын тээврийг Чи көү хүртэл нээсэн нь Алшаагийн хошууд хошууны давсыг хятад газарт тээвэрлэн худалдаалах явдал улам өргөжихөд чухал нөлөө үзүүлсэн байна. Тийнхүү Чингийн төр усан замаар давс тээвэрлэж, худалдаалахыг зөвшөөрсөн нь өнгөц харахад худалдааны нээлттэй бодлого хэрэгжүүлсэн мэт боловч үнэн хэрэг дээрээ цаанаа тодорхой хэмжээний хязгаарлалт, хяналтын бодлогыг үргэлж баримтлан явуулж байсныг мөн дурдах хэрэгтэй. Үүнийг Тэнгэр тэтгэгчийн үеийн усан замаар давс тээвэрлэх онгоцны тоонд хязгаарлалт тавих, онгоц хийх иргэдийн хоол ундны зардалд хязгаарлалт хийх, усан онгоц хийх модонд хориг хязгаар тавих зэрэг бодлого илтгэнэ. Эндээс Чингийн төр аль ч үед монгол хошуудын давстай холбоо бүхий асуудалд нарийн зохион байгуулалттай, хянамгай бодлого хэрэгжүүлж байсан нь харагддаг. Тухайн үеийн давсны бодлогод тулгарч асан гол асуудлууд нь давсны татварын янз бүрийн дарамт, авлигал, хүнд суртал, хууль бус давсны худалдаа, давсны борлуулалтын хувь хэмжээ буурах, албан татварын өр зэрэг байв.

Чин улсын эхэн үеийг бүхэлд нь авч үзвэл, авч хэрэгжүүлсэн төрийн давсны бодлогын үндсэн агуулгыг:

- Давсны татварыг газар тариалан болон хүн амд дүйцүүлэн татах бодлого
- Давсан тэмдэгтийн бодлого
- Бусад газрын давсаар дотор газрын давсны хомсдолыг нөхөх бодлого зэргээр тодорхойлж болно.

XVIII зууны сүүл үе болж ирэхэд Чин Улсын Хэдун зэрэг газрын давст нуурууд удаа дараа үерт автаж, давсны ургац гарц муудаж, олборлолт бууран, зах зээлийн үнэ огцом өсөж, давсны хомсдол үүссэн байна. Тиймээс түшмэл

Агуйн өргөсөн айлтгал болон Тэнгэрийн тэтгэсэн хааны 56-р он [1791он]-ы 8-р сард Шаньси-гийн шинээр томилогдсон Цагдан байцаагч сайд Фэн Гуаншион-ы саналын дагуу Чингийн төр нэгэн онцгой шийдвэр гаргасан байна. Энэ нь Тэнгэр тэтгэгч хааны 57-р оны (1792) 2-р сард “Давсны татварыг газар тариалангийн адил хүн амд дүйцүүлэн бодох” дүрэм баталж, энэхүү дүрмийг албан ёсоор хэрэгжүүлж эхэлсэн явдал болно. Ингэснээр давсны татварыг тусад нь авахгүйгээр газар тариалангаас авдаг татвартай адил бүх хүн амд ногдуулан хураах болсон юм. Тийнхүү татварын тогтолцоогоо өөрчлөхийн хамт давсны яам, албадыг ч татан буулгажээ³⁰. Харьцангуй олон жил мөрдсөн тэрхүү дүрэмд 16 зүйл заалт орсон бөгөөд үндсэн агуулгыг нь дараах байдлаар хураангуйлан өгүүлж болно. Үүнд:

1. Давсны татварыг газар тариалантай адил хүн амд дүйцүүлэн оноож авна. Давсны татварыг жил бүр төлөх ёстой ба татварын өр төлбөргүй байх ёстой.
2. Давсны тээвэрлэлт, борлуулалтад мөрдөж асан албан давсны худалдаачны онц эрхийг хасах, давс борлуулах зах зээлийн хязгаарлалтыг зогсоох, хувь хүмүүс давсны тээвэрлэлтийг чөлөөтэй явуулах боломжийг олгох, орон нутгийн албан тушаалтнууд үүнд саад учруулахыг хориглох, тэдний хувиараа татвар хураахыг болиулах.
3. Захиргаа удирдлагын хувьд, давсны түшмэлүүдийг татан буулгаж, хяналт шалгалт, эргүүлийн үүрэг бүхий 3 байцаагчтай болгох.
4. Давст нуураас давс олборлох хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор давсны үйлдвэрлэлийн тогтолцоог бэхжүүлэх зэрэг багтаж байв.

Энэхүү бодлогын эерэг талыг тодорхойлбол дараах хэдэн зүйлийг онцлон хэлж болно. Үүнд:

- Давсны татварын жилийн орлогыг баталгаажуулсан.
- Давсны тээвэрлэлтийн зардлыг бууруулсан. Давсны захиргааны албан тушаалтнуудын хориг хязгаарлалтыг халж, тээвэрлэлт, борлуулалтын ганцаар эзэгнэх явдлыг халснаар хувиараа давсны наймаа эрхлэгч иргэдийн оролцоо нэмэгдэж, зах зээл идэвхжиж, давсны тээвэрлэлтийн зардал эрс буурсан.
- Тээврийн зардал багассанаар давсны үнэ буурч, давсны худалдаачид, иргэдийн аж амьдралд эергээр нөлөөлсөн зэргээр тодорхойлж болно. Гэвч энэ бодлогод сөрөг тал бас байсан юм. Энэ нь:
- Энгийн иргэдийн нуруун дээрх ачаалал нэмэгдсэн. Жишээ нь, тариачид тариалангийн татвар төлөхийн зэрэгцээ албан худалдаачдын төлөх ёстой давсны татварыг хуваалцан, давс хэрэглэгчийн хувьд нэмж татвар төлөх болсон.
- Газрын эзэд дээрх бодлогоор шалтаглан талбайн түрээсээ нэмэх болж, энэ нь жирийн иргэдийн нуруун дээр дарамт болж буусан байна.

³⁰ 《阿拉善左旗档案馆馆藏档案》，全宗号：101-0003-0045-0118。

Давсны татварыг газар тариалангийн татвартай адил бүх хүн амд дүйцүүлэн оноох бодлогыг хэрэгжүүлсний гол зорилго нь давснаас олох татварын орлогыг тогтмолжуулж, таслахгүй үргэлжлүүлэхэд оршиж байв. Давсыг урьд нь зөвхөн албан давсны худалдаачид зарж, борлуулдаг байсныг болиулж, хувь хүмүүс ч давс зөөж тээвэрлэж, зарж борлуулахыг зөвшөөрснөөр 1800 он гэхэд Ганьсу муж дахь давсны зах зээлийн 60 хувийг, Шаньси муж дахь давсны зах зээлийн 30 хувийг Алшаа хошууны давс эзлэх болоод байв.³¹ Ийнхүү Хятад газарт Алшаа хошууны давс ихээр борлуулагдах болсон нь нөгөө талд албан давсны худалдаа, түүнээс олох татварын орлогын хувь хэмжээ буурах, улсын орлого, сан хөмрөг бүрдүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлэх болжээ. Эсрэгээрээ Алшаа хошууны хувьд давс ихээр борлуулагдах болсноор хошууны амьдралд эергээр нөлөөлж, түүнээс ихээхэн хэмжээний ашиг олж байлаа. Тийнхүү улсын албан давсны худалдаанд сөргөөр нөлөөлж байсан нь Чингийн төрийн анхаарлын гадна үлдсэнгүй, яаралтай арга хэмжээ авахад хүргэжээ. Нөгөөтэйгүүр, Сайшаалт ерөөлт (1796-1820)-ийн үед Чин улсын давсны бодлогод тулгарсан бас нэг асуудал нь давсны хууль бус худалдаа наймаа газар авсан явдал юм. Энэ хэрээр төрийн давсны татвараас олох мөнгөн орлого багасах, давсны хомсдол үүсэх, давсны борлуулалтын хувь хэмжээ буурах сөрөг үзэгдэл бий болж байв. Дээрх асуудлууд нь бие биеэсээ харилцан хамааралтайгаар үүссэн байна. Албан давсны татвар хэт өндрөөс шалтгаалж, давсны үнэ өсөх тул ард иргэд үнэтэй давс худалдаж авахын оронд хууль бусаар орж ирэх хямд давс худалдан авах сонирхолтой байв. Үүний учир нь уламжлалт давсны бодлого болох албаны хяналт дор хэрэгждэг давсны худалдаачны дүрмийн сул талд оршиж байв. Албан давсны худалдаачны дүрэм нь албаны түшмэл, худалдаачин хоёр сүлбэлдэн хамсрах, хямд үнэтэй давсыг хулгайгаар үнэтэй зах зээлд оруулж борлуулан ашиг олох зэрэг боломжийг тэдэнд олгож байсан ажээ. Иймээс Сайшаалт ерөөлт хаан давсны бодлогод шинэчлэл хийх арга хэмжээ авсан ба гол агуулгыг нэгтгэн үзье. Үүнд:

1. Давсны татварын бодлогод шинэчлэл хийж, төрийн бодлогоор журамлан зохицуулах,
2. Давсны худалдаачдын талаарх бодлогыг өөрчлөх,
3. Давсны хууль бус худалдааг таслан зогсооход чиглэж байв. Өмнө нь Чингийн төр татварын өртэй давсны худалдаачдад харьцангуй хүлээцтэй хандаж, ихэнх тохиолдолд тэднийг шийтгэдэггүй байсан бөгөөд давсны худалдаачид төрд татварын өртэй байхыг хэвийн явдал гэж үздэг болоод байсан бол Сайшаалт ерөөлт хааны үед татвар төлөх хугацаа хэтэрсэн болон татварын өртэй давсны худалдаачдыг мөнгөөр торгох, ташуурдах, дөнгө зүүлгэх, шоронд хорих зэргээр гэсгээн шийтгэх дүрэм гарган хэрэгжүүлсэн юм. Энэ нь зохих хэмжээний эерэг нөлөө үзүүлсэн боловч худалдаачин болон албан түшмэлийн хоорондын харилцаанаас үүдэлтэй хээл хахууль, худалдаачдын төрд эзлэх байр суурь дээшилсэн зэргээс шалтгаалж хангалттай үр дүнд хүрч чадаагүй байна.

³¹ 《清经世文编》(1992),《户政二四》,卷49,北京,中华书局。

Давсны хууль бус худалдааг таслан зогсоох үүднээс худалдаачид өөрсдөө тээвэрлэн борлуулах дүрмийг өөрчилж, албанаас буюу төрөөс тээвэрлэн борлуулах дүрэм гаргажээ. Энэ үеийн албан давсны худалдаачны дүрэм ёсоор бол тусгай албаны худалдаачин заан тогтоосон зах зээлд давс тээвэрлэн хүргэж борлуулах үйл ажиллагааг эрхэлдэг онцлогтой байв. Гэвч асуудлыг бүрэн гүйцэд шийдэж чадаагүй юм. Чин улсын зарим түшмэдийн айлтгалаас харахад, албан давсыг ард иргэдэд худалдаалахдаа давсанд элс, шороо холих, жин хэмжээг дутагдуулах зэрэг зөрчил гарсаар байжээ³². Юутай ч Сайшаалт ерөөлт хааны үед тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэх зорилго тавьж тодорхой алхам хийсэн хэдий ч тэдгээр шинэчлэл нь зарим нэг жижиг асуудлыг шийдвэрлэхээс хэтрээгүй буюу асуудлыг үндэс сууриар нь шийдэж чадаагүй гэж болно.

Давсны хатуу хяналтыг үгүй болгосноор Алшаагийн Хошууд хошууны давс хятад газарт чөлөөтэй нэвтрэх, Хатан голын доод урсгал дахь бүс нутгийн зах зээлийг эзлэн тэлэх боломж нээгдсэн байна. Тухайн үеийн баримтуудаас харахад энэ үед Хуайнань (淮南-huai nan), Хуайбэй (淮北-huai bei) дахь давсны зах зээл Алшаа давсны хязгаарлалтгүй худалдааны нөлөөлөлд өртсөн ажээ. Хэдийгээр Тэнгэрийн тэтгэсэн (1736-1796)-ий үеэс хойш л гэхэд Алшаа хошууд хошууны давстай холбоотой бодлогын өөрчлөлт хэд хэдэн удаа явагдаж, төрийн бодлого, зах зээлийн эрэлт хэрэгцээ зэрэгцэн тавигдаж, хөгжлийн нэгэн үеийг туулсан бөгөөд Алшаа хошууд хошууны давс нь Хятад газрын давсны зах зээл болон эдийн засагт гүн гүнзгий нөлөө үзүүлэх болсон юм. Түүгээр ч үл барам Сайшаалт Ерөөлт (1796-1820)-ийн үеэс эхлэн Алшаа хошууд хошууны Цагаанбулагийн давсыг Ганьсу зэрэг мужууд руу хүргэн борлуулах болсон байдаг. Үүнтэй холбогдуулан нэгэн баримт дурдахад, Сайшаалт ерөөлтийн 5-р онд (1800) Ганьсу-гийн байцаагч түшмэл Жанькайянь хэмээгч давсны татварт өөрчлөлт оруулахаар айлтгал өргөхдөө:

“Дундад харуулын газрын хилийн хэрмийн гадна их, бага хоёр давст нуур бий. Эдүгээ Алишаа оронд харьяалагдмуй. Түүний давс нь цагаан өнгөтэй бөгөөд сайхан амттай тул дотор газрын иргэд цөм идэх дуртай бөлгөө. Хувийн худалдаачид нь хойно хойноосоо цувралджээ. Бүх Ганьсу мужаар авч үзвээс, Хуамачи давст нуурыг идэгсэд нь зөвхөн 3\10 төдий. Эл шянь-ий хувийн давст нуурын давсыг идэгсэд нь 1\10 буюу. Харин Алишаагийн давсыг идэгсэд нь 6\10-д хүрчээ. Шэньси мужийн 3\10 нь гагцхүү тэр давсыг идмүй. Сонсвоос, Алишаагийн засаг ноён хоёр нуурт түшмэл суулгаж, гааль татварлан, хятад, монгол хэмээн ялгахгүй тэдний дураар зөөвөрлүүлмүй...”³³, “Баруун захад байришиж байгаа Цагаанбулаг, Улаан хоёр нуурын давс нь бүгд Ганьсу-д борлуулагдан гайхагдаж байна”³⁴ гэх зэргээр шогшрон өгүүлсэн баримтаас энэ бүхнийг харж болно. Алшаагийн хошууд хошуунд байх, хэн хүний хараанд өртөж, шүлсийг нь гоожуулсан давсны бас нэг баялаг орд нь Жартай нуур байв.

³² 李璐男; (2022), 《清中期吉兰泰盐务管理制度的调适过程》, 盐业史研究 (04) 40-49.

³³ Жанмү. (1990). Монголын хошуу нутгийн тэмдэглэл. (Намюнь монголчлов). Улаанбаатар: Үндэсний Хэвлэлийн Хороо, т. 448.

³⁴ Боржигид Д. (2002). Алишаа Хошууд: Дээд дэвтэр. Хөх хот: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо, т. 288

Сайшаалт ерөөлт хаан Монгол хошуудын давсны явдлыг журамлан, нэн ялангуяа худалдаачид монголчуудтай нийлэн элдэв хэрэг дэгдээх, харуулын нутагт худалдаа хийхийг бүрмөсөн хориглох арга хэмжээ авч байв. Ялангуяа, монгол, хотон, хятад иргэд өөр хоорондоо нууцаар сэм сүлбээлж, худалдаа арилжаа хийхийг хатуу хянах болсон байна. Түүний нэг жишээ бол уйгур худалдаачин Ма Жүньшюань (马君选-ma jun xuan)-тай холбогдох хэрэг явдал болно. Энэ үйл явдалтай холбоотойгоор Жартайн давст нуур Чингийн төрийн мэдэлд шилжсэн түүхтэй. Энэ үйл явдлыг тодруулбал: 1756-1805 оны хооронд Хөх нуурын Шинин (西宁-xi ning)-ий уйгур худалдаачин Ма Жүньшюань гэгч Алшаад Жартайн давсны худалдааг хариуцан ажиллаж байжээ. Тэрээр Алшаа хошууны засаг чин вангаас давст нуурын баялаг ашиглах эрхийг олж, түүний түрээсэнд эхэн үедээ жил бүр 1-2 түмэн лан мөнгө төлж байв. Тэнгэрийн тэтгэсний сүүл үед Чин улсын Алшаагийн Хошууд хошууны давсны үйлдвэрлэлд тавих бодлого, хяналт суларсныг ашиглан Жартайн давсыг усан замаар урагшаа тээвэрлэж, Хэдун-ы зах зээлийг эзэлснээр барахгүй Хэнань зэрэг газарт хүрч, Хуай давсны зах зээлд нөлөөлөх болсон байна. Энэхүү нөхцөл байдлыг хязгаарлахын тулд 1800 онд Чингийн төрөөс Жартайн давст нуурын давсыг усан замаар зөвхөн Шаньси мужийн Чи көү хүртэл л зөөх журам гаргаж, хууль бус наймаатай тэмцэх тусгай түшмэл томилсон байна. Түүнчлэн 1803 онд Хатан голын доод урсгал дагуу боомтын албан хороог нэмэн байгуулж, байцаагч түшмэл томилон суулгажээ. Гэвч хууль бусаар давс тээвэрлэн худалдах явдлыг ул суурьтай шийдвэрлэж чадаагүй билээ.

Энэ үеэр буюу 1805 онд Хубэй (湖北-he bei) мужийн Жяньшя-гийн уугуул Шя Бинхү (夏秉湖-xia ning hu) гэгч Яргайд эмч хийж байгаад хожим Динюань-д очиж, Алшаагийн засаг ноёныг эмчлэх явцдаа Шаньси-гийн Чи көү дэх Алшаа давсны худалдаа ихээхэн ашигтай гэдгийг олж мэджээ. Улмаар Шя Бинхү Бээжингийн худалдаачин Рэн Гөүпин (仁国平-ren guo ping)-тэй холбоолон Алшаагийн давсны арилжаанд оролцохыг хүссэн байна. Алшаа чин вангийн гарын түшмэл Ян Хафэнга-гийн дэмжлэгтэйгээр Шя Бинхү чин вангийн зөвшөөрлийг олсон төдийгүй мөнөөх Ма Жүншюань худалдаачныг солихыг зөвшөөрүүлсэн боловч тэрээр үүнийг хүлээж аваагүй ажээ. Тиймээс Шя Бинхү үүнд өсөрхөж, давсны худалдаачин Ма Жүншюань-ийг улсын татвараас зайлсхийсэн хэмээн ГМТЗЯЯ-нд зарга мэдүүлсэн байна. Энэ дагуу уг хэргийг шүүн таслахыг Ганьсу-гийн Жунду-д даалгаж, зарлигийн дагуу Ма Жүншюань-ийг баривчлан, Лань жөү-д хүргэхийг Алшаа хошууны тамгын газарт тушаажээ.³⁵

Шүүх хурлын үеэр Ма Жүншюань гэм буруугаа хүлээсэн ба Яамны ноёдын өчиг, хотон хүн атал Алшаа чин вантай сүлбэлдэж, хууль бус давсны наймаа эрхэлсэн хэрэг нь Чин улсын “Гадаад засгийн иргэд хоорондоо сүлбэлдэн нууцаар худалдаа явуулах, татвараас зайлсхийж болохгүй хэмээх журмыг зөрчсөн” явдал гэж үзсэн байна. Иймд түүнийг албан тушаалаас нь огцруулж, хил хязгаар нутаг руу цэргийн албанд явуулах ял оноожээ. Гэвч Ма Жүншюань хөгшин настай,

³⁵ 《清仁宗实录》，卷138，嘉庆九年十二月壬午条。

бие сул дорой тул гэмт хэргээ цагаатгахын тулд эд хөрөнгөө зарж, 30 мянган лан мөнгө төлүүлэн ялаас хэлтрүүлж өгөхийг хүссэн байна. Түүний уг хүсэлтийг албаны сайд, түшмэд зөвшөөрч, 30 мянган лан мөнгийг албанд хураан авч, тус мужийн цэргийн хэрэглээнд зарцуулжээ. Шя Бинхү-г ч мөн адил ялтай хэмээн хэргэм зэргийг нь нэгээр бууруулж, 100 ташуур жанчин, гурван жил шоронд хорих ялаар шийтгэжээ.³⁶

Шя Бинхү-гийн заргын улмаас Ма Жүньшюань-ийг баривчлан шийтгэсэн хэрэг явдлаас үүдэн Шаньси-гийн Чи көү дэх Алшаагийн давсны асуудлыг хариуцах хүнгүй болоход хүрсэн байна. Алшаагийн монголчууд мөн давсны хэргийг зохицуулж хүчрэхгүй байсны дээр хятад худалдаачдаас уг ажилд тохирох хүн хайхад хүрсэн боловч олдоогүйн улмаас асуудал үүсжээ. Үүний зэрэгцээ Ма Жүньшюань-ий хэрэгт Алшаагийн засаг ноён өөрөө нэр холбогдсоноос болж, төрийн зарим түшмэд Алшаагийн засаг ноёнд хариуцлага тооцохыг санал болгосон тул цөхрөнгөө барсан Алшаагийн засаг ноён Жартайн давст нуурыг төрд өргөхөөр айлтгал өргөжээ. Тэрхүү айлтгалын бичигт:

“Мэхийж санаваас, боол Махбал би элэнц өвөг, эцгээс нааш үе улиран Богд эзнээс хишгийг хүртсэн нь маш хүнд. Боолын захирах монгол боолчууд цөм түгээмэл хишгийг нийтээр хүртэв. Гагцхүү монгол боолчууд цөм мал цөөхөн бөгөөд давс ачихуй дор итгээж өдөр бүр амь зуумуй. Эдүгээ цаазалсан хуулийг дагаж, Дотоод иргэнтэй сүлбээлэн яваагүй монголчууд биеэр шийтгүүлсэн боловч монгол боолчууд шийтгэн зөөх чинээгүй болоод эдүгээ хүртэл зогссон билээ. Бас Монгол газар ган болоод монгол боолууд гачигдаж зүдрэхэд хүрэв. Иймээс боолын захирах монгол боолууд мэхийн санаваас, Богд эзэн түмэн газрыг өршөөн санах бөгөөд Жартайн давс хэмээх нь мөн Богд эзний газраас гарсан тул боолчууд нийтээр зөвшиж, дээр барихуйг хүсэхүйд боол Махбал айн эмээж, Богд эзний өршөөлийг залбиран санах нь, боол үе улиран тэнгэрийн хишиг хүртсэн бөгөөд эдүгээ боолууд нэг санаагаар энэ монгол давсыг Дээдсийн санд оруулж, давсны гаалийн албанд хэрэглэж, Дэн көү-д хүргэх тэмээн ачааны хөлсийг боолын захирах үгээгүй ядуу монголчуудад итгээж хүртээвээс амь зуухад тустай болмуй. Энэ давсыг Богд эзэнд өргөвөөс мөнхүү сангийн давс болох тул зоригоор зах хязгаарыг дагаж, хулгайн давс явуулахыг үүрд тасалж болмуй. Боол Махбал айн эмээж, орд харишийн зүг хандаж толгойгоо мөхийж гүйх явдлыг Амбан яамнаас учрыг гаргаж, уламжлан өргөх ажаамуу. Үүний тул Сайшаалт Ерөөлтийн 11-р оны зуны дунд 12” гэжээ.³⁷

Энэхүү өргөх бичгийн дагуу 1807 онд Чингийн хааны зарлигаар Алшаагийн Хошууд хошууны Жартайн давст нуур хошууны мэдлээс Чин улсын төрийн мэдэлд шилжжээ. Дээр дурдсанчлан Ма Жүншюань-ий хэрэгт Алшаагийн хошууд хошууны засаг ноёны угсаа залгамжлагч Махбал нэр холбогдсон бөгөөд үүнээс болж Махбал ч бас Чин улсын хуулийн дагуу шийтгэл хүлээхэд хүрээд байсан юм. Тиймээс Жартайн давст нуурыг Чингийн төрд өргөн барьсан энэ явдал Махбал ял шийтгэлээс эмээж, өөрийгөө аврах гэсэн байна. Гэхдээ уг давст нуурыг төрд өргөн барьсан хамгийн чухал шалтгаан нь Жартайн ордын

³⁶ 《清仁宗实录》，卷129，嘉庆九年五月丙申条。

³⁷ 《阿拉善左旗档案馆馆藏档案》，全宗号：101-0004-0171-0002。

үйлдвэрлэлийг хариуцаж байсан Ма Жуньшюань арга зам эрэлхийлсэнтэй холбоотой гэж үзэж болно. Нөгөөтэйгүүр энэ нь Чингийн төрийн эрх ашиг, хүсэл сонирхолд нийцэж байсан юм. Гол хариуцагч нь албан татвар төлөхөөс зайлсхийсэн хэргээр шийтгэгдэж, давст нуурын үйл хэргийг үргэлжлүүлэн удирдах, борлуулалтыг хариуцах хүнгүй болж, давсны үйлдвэрлэл үндсэндээ зогсонги байдалд ороод байсантай энэ нь холбоотой байв. Аль нь боловч давст нуурын ордын үйл ажиллагааг эргэн сэргээх, борлуулалт, ашиг орлогыг урьдын адил болгохын тулд Алшаагийн Хошууд хошууны засаг ноёны залгамжлагч Махбал төрийн мэдэлд уг ордыг шилжүүлсэн гэж хэлж болно. Алшаагийн Хошууд хошуу дангаараа Жартайн давсны олборлолт, тээвэрлэлт, хамгийн гол нь борлуулалтын асуудлыг хариуцахад хүндрэлтэй байсан тул тус ордыг үр ашиггүй, зогсонги байдлаар байлгаад байхыг хүсээгүй талтай. Түүнчлэн Чингийн төр ч энэ нөхцөл байдлыг овжин ашиглаж, Ма Жуньшюань-ий хэрэг явдлын далимаар нуурыг төрийн мэдэлд авах, ингэснээрээ албан давсны худалдаа, түүний зах зээлийг хамгаалах, Алшаагийн давснаас улсын сан хөмрөгт орох мөнгөн орлогыг хяналтдаа оруулах бодлого хэрэгжүүлэх боломжийг гартаа авсан хэрэг юм. Тэрчлэн Махбал Жартайн давст нуурыг Чингийн төрд өргөн барьснаар ял зэмээс өршөөгдөхийн сацуу тус хошууг залгамжлан захирах засаг ноёны эрхээ баталгаажуулсныг үгүйсгэх аргагүй билээ.

Дээрх мэт олон шалтгааны улмаас Сайшаалт ерөөлтийн 11-р он [1806 он]-д Чингийн төр давсны татварыг хүн амд дүйцүүлэн оноох бодлогыг зогсоож, албан давсны худалдаачны дүрмийг эргэн сэргээснээр дээрх шинэчлэлийн бодлого төгсгөл болжээ. Бодлогодоо өөрчлөлт оруулан хэрэгжүүлэх болсны бас нэг жишээ нь 1806 оноос Алшаа хошууны Жартайн давст нуурыг Чингийн төр өөрийн мэдэлд буюу улсын мэдэлд авсан явдал болно. Тэр үед Манж Чин улсын төрөөс Хөх хотын Хэ көү хүртэл Алшаа давсыг зөөхийг зөвшөөрсөн шийдвэрийг гаргаж, улмаар Алшаагийн хошууд хошууны давсыг шууд Шаньси-гийн дунд хэсгийн Чи көү хүртэл усан замаар тээвэрлэн, борлуулахыг зөвшөөрсөн нь эдийн засгийн чухал ач холбогдолтой түүхэн шийдвэр байв. Үүний үр дүнд Алшаагийн хошууд хошууны давсны үйлдвэрлэл, борлуулалт үлэмж нэмэгдэж, хошууны иргэдийн амьдрал ахуйд эерэг нөлөө үзүүлж, хятад газрын зах зээлд монгол хошуудын давсны борлуулалтын хувь хэмжээ өсөж, давсны эрэлт хэрэгцээг хангахад чухал нөлөө үзүүлсэн байна. Мөн түүнчлэн Чингийн төрөөс Шаньси-гийн умард нутгийн хятад иргэд зөвшөөрлийн бичиг аваад, боомтын гадна гарч давс худалдан авахыг зөвшөөрсөн нь хятад газарт үе үе үүсдэг байсан давсны хомсдолыг арилгах, түүнийг шийдэх гэсэн оролдлоготой холбоотой ажээ. Монголчуудын хувьд уламжлалт мал аж ахуйг түшиглэн аж төрсөөр ирсэн учир давс тээвэрлэн Шүрэгийн боомтод хүргэх үйл хэрэгт төдийлөн идэвхтэй оролцож байгаагүй тул Чингийн төр хятад худалдаачдыг энэ ажилд идэвхийлэн хамруулж, зах зээлд үүсээд буй давсны эрэлт хэрэгцээг хангахыг хичээж байжээ. Алшаагийн хошууд хошууны давсны борлуулалт үлэмж нэмэгдсэн нь хошууны амьдралд ч, давс тээвэрлэдэг жинчдийн ашиг орлогод ч эерэг нөлөө үзүүлжээ. Нөгөөтэйгүүр

Алшаа хошууны давсны олборлолт, борлуулалт өссөн нь Чин улсын албан давсны борлуулалт эрс багасахад нөлөөлж, давсны зах зээлд эзлэх хувийн жин нь ихэд буурахад хүргэсэн байна. Үүнээс үүдэн Чингийн төр аядуу зөөлөн бодлогоо эргэн харахад хүрч, албан давсны үйл хэргийг хамгаалахад чиглэсэн хэд хэдэн арга хэмжээ авсан юм.

Чингийн төр Монгол хошуудад давсны бодлогоо хэрэгжүүлэхдээ нэг талаас аядуу зөөлөн чиг шугам баримтлахын сацуу цаагуураа өөрсдийн эрх ашгийг давхар харгалзан хамгаалсан, шаардлагатай үед хязгаарласан бодлого явуулдаг байсан нь түүхээс харагддаг. Үүний нэг жишээ бол усан замын давсны тээвэр хийгээд онгоц хийх мод, онгоцны тоо, онгоц хийх урчуудын хүнсний хэрэглээ зэрэгт хязгаарлалт тавьж байсан явдал болно. Үүнийг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт №1. Чин улсын эхэн үед Алшаагийн Хошууд хошуунаас усан замаар тээвэрлэсэн давсны хэмжээ, онгоц болон модны тоо

<i>Он цаг</i>	<i>Модны тоо</i>	<i>Онгоцны тоо</i>	<i>Ачсан давсны хэмжээ</i>	<i>Архивын дансны дугаар</i>
1786 оноос өмнө	Тодорхой биш	50	1400000	БНХАУ-ын Өвөр Монголын Алшаа зүүн хошууны архивын данс. 101-0003-0051-0201
1786-1790 он	10000	600	16800000	101-0003-0051-0201
1791-1804 он	9000	500	14000000	101-0003-0052-0051
1805-1812 он	6000	333	10000000	101-0004-0078-0052
1812 оноос хойш	Усан замын тээврийг хориглосон.			101-0005-0193- 0070

Энэхүү тоон мэдээлэл нь Алшаагийн хошууд хошууны онгоц хийх модны тоо, давс ачих онгоцны тоо, олборлон ачих давсны хэмжээ харилцан хамааралтай, энэ нь төрийн бодлоготой холбоотой бөгөөд сүүл рүүгээ урвуу хамаарлаар буурч байгаа нь Чингийн төрийн албан давсны зах зээлээ хамгаалах бодлогын нөлөө тусгалыг илтгэнэ.

Чингийн төрийг түгшээж байсан өөр нэг зүйл нь Алшаагийн хошууд хошууны давсны үйлдвэрлэлд зориулж худалдаалсан гурил будаа, онгоцны мод, түүгээр хийсэн онгоц зэргийг давсны хамтаар Шаньси мужийн дунд болон өмнөд хэсэгт хууль бусаар зарж, худалдан борлуулж, төрийн хяналтаас гадуур ашиг олох явдал гарч байсанд оршино. Энэ явдлыг таслан зогсоохын тулд Чингийн төр гурил будаа, онгоцны мод зэргийг хэнээс, хаанаас, хэр хэмжээтэй авсан зэргийг бүртгэдэг байв. Алшаагийн хошууд хошуунд хэрэгжүүлсэн Чингийн төрийн давсны бодлогын мөн чанар нь төрийн эрх ашгийг ямагт түрүүнд тавих явдал байсан нь тодорхой харагддаг ба төрийн эрх ашигт ноцтой сөрөг нөлөө үзүүлээгүй буюу чухал шаардлага тохиолдсон нөхцөлд дэмжсэн бодлого хэрэгжүүлж, харин сөргөөр нөлөөлөх хандлага илэрсэн үед хяналт, хязгаарлалтын хатуу бодлого явуулдаг байсан онцлогтой байна. Чингийн эхэн үед төрийн зүгээс давсны бодлогоо тухайн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан

явуулж, зарим өөрчлөлт, шинэчлэлт хийж ирсэн, энэ нь зарим тохиолдолд эерэг үр нөлөөг, зарим тохиолдолд сөрөг үр дагавар дагуулсаар ирсэн байна. Цаг үетэйгээ уялдуулан олон өөрчлөлтийг хийхийг оролдож байсан ч бүхэлд нь авч үзвэл, Чингийн төрийн давсны бодлогод “Албан давсны худалдаачны дүрэм” голлох байр суурийг эзэлсээр иржээ. Чингийн төр давсны бодлогод өөрчлөлт, шинэчлэлт хийхдээ төрийн эрх ашгийг ямагт эн тэргүүнд тавьж иржээ.

Эцэст тэмдэглэхэд, Манж Чин улсын эхэн үе буюу 1731-1807 оны хооронд Алшаагийн хошууд хошууны давст нууруудад явуулсан бодлого нь дараах хоёр чиглэлийн хүрээнд хэрэгжсэн байна. Нэгдүгээрт, Чингийн төр давсны ерөнхий бодлогынхоо хүрээнд Монгол хошуудын давсыг Цагаан хэрмийн арын бүс нутгийн зах зээлд бага хэмжээгээр, иргэдийн эрэлт хэрэгцээг хангах байдлаар нэвтрүүлэх бодлогыг анх баримталж байжээ. Улмаар нэгэнт цаагуураа далд хэлбэрээр хятад газарт нэвтэрч байсан Монгол хошуудын давсны хууль бус наймааг таслан зогсоох, хязгаарлах, түүнээс татвар хураах замаар улсын санд мөнгөн орлого татан төвлөрүүлэх бодлого руу шилжсэн байна. Зөвхөн хуурай замаар Шүрэгийн боомтод давсны татвар тушаагаад Хятад газар буюу Шаньси-гийн умард хэсэгт хошууны давсыг худалдан борлуулахыг зөвшөөрсөн нь Монгол хошуудтай холбоо бүхий Чингийн төрийн давсны бодлогын нэг шинэ алхам болсон юм.

The salt policy implemented by the state at the beginning of the Manchu Qing Dynasty

(Based on the example of the Alshaa khoshuu)

In the early Qing Dynasty, the state implemented its salt policy in line with the circumstances of the time, making some changes and reforms, which in some cases had positive effects and in some cases had negative consequences. Although many changes were attempted in line with the times, overall, the “Official Salt Merchant’s Rule” continued to occupy a central position in the salt policy of the Qing state. The Qing state always put the interests of the state first when making changes and reforms in salt policy. Finally, the policy implemented in the salt lakes of the Alasha counties in the early Qing Dynasty, between 1731 and 1807, was implemented in the following two areas. First, the Qing state initially adopted a policy of introducing salt from Mongolian counties to the markets behind the Great Wall in small quantities to meet the needs of the people. Subsequently, the policy shifted to a policy of stopping and restricting the illegal trade of salt from the Mongol provinces, which had been secretly entering Chinese territory, and collecting taxes from it to collect cash income for the state treasury. The decision to pay salt taxes only at the port of Shure by land and allow the provinces to sell their salt in northern China, namely Shanxi, was a new step in the Qing government’s salt policy in relation to the Mongol provinces.